



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/18-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс:976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<p>ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.БАТТУЛГА ТАНАА</p>
<u>2023-03-24</u> № <u>146</u> танай _____ -ны № _____ -т	
<p>Өөрчлөлтгүй дүгнэлт</p>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<p>Дүгнэлтийн үндэслэл</p>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<p>Асуудлыг онцолсон хэсэг</p>	
<p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн, мөрдөж эхэлсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогууд сумын төсвийн орлогод нэмэгдэж төвлөрсөн байна.</p>	
<p>Бусад асуудлын хэсэг</p>	
<p>Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 77.8 хувьтай үнэлсэн байна.</p>	
<p><i>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.</i></p>	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	738,535.1	630,751.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	265,437.2	311,169.8
33	АВЛАГА	334,725.0	309,535.1
35	БАРАА МАТЕРИАЛ	138,373.0	10,046.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,225,219.6	1,879,676.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,225,219.6	1,879,676.3
39200	Биет хөрөнгө	6,156,721.6	1,879,676.3
39300	Биет бус хөрөнгө	68,498.0	12,057.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,963,754.7	2,510,428.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	626,924.4	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	626,924.4	0.0
41300	Өглөг	626,924.4	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,336,830.3	2,510,428.0
51	Засгийн газрын хувь оролцоо	6,336,830.3	2,510,428.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,964,479.1	433,047.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.0	433,047.4
51200	Хуримтлагдсан үр дүн	-94,502.4	1,355,318.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,466,853.7	722,061.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,963,754.7	2,510,428.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,790,019.1	2,287,540.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	278,038.2	347,290.4
110	Орлогын албан татвар	97,723.4	248,640.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	97,723.4	248,634.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	6.3
113	Хөрөнгийн албан татвар	100,654.4	82,371.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	79,660.4	16,278.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	409,424.8	431,176.3
120	Нийтлэг татварын бус орлого	409,424.8	431,176.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,102,556.1	1,509,073.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,640,726.6	1,760,642.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,640,726.6	1,756,242.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,556,267.1	1,706,623.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,865,071.8	363,083.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,501.4	43,725.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	479,112.8	1,060,370.0
2104	Хангамж, бараа материалын зардал	77,205.3	35,877.8
2105	Нормативт зардал	455,188.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,941.3	30,577.3
2107	Томилолт, зочны зардал	5,307.7	3,994.0

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,646.7	22,539.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,291.4	146,456.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,459.6	49,619.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	4,400.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	149,292.5	526,897.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	60,509.9	4,934,654.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	88,782.6	-4,407,756.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,433,747.9	1,958,393.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	278,038.2	347,290.4
110	Орлогын албан татвар	97,723.4	248,640.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	97,723.4	248,634.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	6.3
113	Хөрөнгийн албан татвар	100,654.4	82,371.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	79,660.4	16,278.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	74,602.0	9,592.7
1181	Газрын төлбөр	2,041.1	3,912.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,017.2	2,773.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,793.9	102,030.2
120	Нийтлэг татварын бус орлого	97,793.9	102,030.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,057,915.8	1,509,073.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,042,869.8	1,647,907.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,042,869.8	1,647,907.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,958,410.2	1,598,288.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,864,137.4	363,083.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,266.6	43,770.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	397,846.2	1,060,112.5
2104	Хангамж, бараа материалын зардал	67,691.5	35,877.4
2105	Нормативт зардал	234,574.9	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,492.8	30,577.3
2107	Томилолт, зочны зардал	5,307.7	3,994.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,144.3	22,539.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,948.7	38,334.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,459.6	49,619.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	390,878.1	310,486.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	120,754.1	174,753.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,754.1	174,753.8
2200	Дотоод эх үүсвэрээр	120,754.1	174,753.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-120,754.1	-174,753.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-56,500.0	-90,000.0

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	56,500.0	90,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	213,624.0	45,732.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,813.2	265,437.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265,437.2	311,169.8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,248,047.8	6,248,047.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,248,047.8	6,248,047.8
9	Тайлант үеийн үр дүн	88,782.6	88,782.6
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,336,830.3	6,336,830.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,336,830.3	6,336,830.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	581,354.4	581,354.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,918,184.7	6,918,184.7
19	Тайлант үеийн үр дүн	-4,407,756.7	-4,407,756.7
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,510,428.0	2,510,428.0

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,144,320.30	1,905,683.00	238,637.30	88.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,706,372.80	1,644,029.20	62,343.60	96.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,659,224.50	1,596,880.90	62,343.60	96.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,907.30	363,083.00	7,824.30	97.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,998.60	43,770.50	1,228.10	97.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,111,905.30	1,060,112.50	51,792.80	95.34
2104	Хангамж, бараа материалын зардал	35,610.40	35,043.40	567.00	98.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,927.30	30,577.30	350.00	98.87
2107	Томилолт, зочны зардал	4,000.00	3,994.00	6.00	99.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,841.00	21,265.60	575.40	97.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,034.60	39,034.60	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,148.30	47,148.30	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,148.30	47,148.30	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	338,897.50	171,653.80	167,243.70	50.65
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	99,050.00	90,000.00	9,050.00	90.86
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,144,320.30	1,843,868.40	300,451.90	85.99
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,845,932.90	1,749,327.30	96,605.60	94.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	298,387.40	94,541.10	203,846.30	31.68

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	131,372.00	-131,372.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	69,557.40	-69,557.40	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	105	105		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	52		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52	52		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,978.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,978.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,507.5
2104	Хангамж, бараа материалын зардал	834.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,273.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,470.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,470.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,507.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,507.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-2,470.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,470.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **210,818.1** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчилийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 6 нэр төрлийн 54,114.3 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 10-р тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д батлуулаагүй 8,000.0 мянган төгрөгийн “Сумын Хүүхдийн цэцэрлэгийн хашаа, хайс шинэчлэх” ажилд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай 60 дугаар зүйлийн 60.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно” гэсний 60.3.6 “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.8 “Энэ журмын 2.5, 2.6 болон 2.7-д заасан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3 Хоршоо хөгжүүлэх санд 35 зээлдэгчтэй холбоотой 148,703.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өлзийт сумын ТТЗ	3	210,818.1	0	0	3	210,818.1	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өлзийт сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0